

*Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2015 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн  
26 тоот тогтоолын  
хавсралт*

## **ҮҮРЭН ХОЛБООНЫ ДУГААРТАЙГАА ШИЛЖИХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ЖУРАМ**

### **1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

#### **1.1. Зорилго**

- 1.1.1. Монгол Улсын Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13 дахь заалтын дагуу дугаартайгаа шилжих үйлчилгээний ерөнхий зарчмыг тогтоох, үүрэн холбооны сүлжээнд хэрэглэгч дугаартайгаа нэг оператороос нөгөөд шилжих нөхцөл, дугаартайгаа шилжих үйлчилгээний төвийн үйл ажиллагааг зохицуулах, үүрэн холбооны операторуудын эрх, үүргийг тодорхойлох, уг үйлчилгээг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах бусад харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.1.2. Энэхүү журмыг мөрдөхдөө Монгол Улсын Харилцаа холбооны тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос гаргасан дүрэм, журам, зохицуулалтын баримт бичиг болон Харилцаа холбооны салбарт мөрдөгдөж буй Монгол Улсын үндэсний стандартуудыг мөрдлөг болгоно.
- 1.1.3. Энэхүү журмыг дугаартайгаа шилжих үйлчилгээний төв, суурин болон үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчид дагаж мөрдөнө.

#### **1.2. Нэр томъёоны тодорхойлолт**

Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

- 1.2.1. “Дугаартайгаа шилжих үйлчилгээ” гэдэг нь хэрэглэгч нэг оператор компанийн бүртгэлээс гарч нөгөө оператор компанид бүртгүүлэн шинээр хэрэглэгч болох үедээ хуучин дугаараа шилжүүлэн хэрэглэх боломжийг олгодог үйлчилгээг;
- 1.2.2. “Донор оператор” гэдэг нь тухайн хэрэглэгч дугаартайгаа шилжих үед шилжүүлэн өгч буй операторыг;
- 1.2.3. “Хүлээн авагч оператор” гэдэгт хэрэглэгч дугаартайгаа шилжих үед шилжүүлэн авч буй операторыг;
- 1.2.4. “Анхны оператор” гэдэг нь хэрэглэгчид тухайн дугаарыг анх олгосон операторыг;
- 1.2.5. “Оператор” гэдэг нь харилцаа холбооны үйлчилгээний сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;
- 1.2.6. “All Call Query (ACQ) арга” гэдэг нь хэрэглэгч дугаартайгаа шилжсэн эсэхээс үл хамааран бүх дуудлагыг шалгадаг дуудлага чиглүүлэх аргыг;
- 1.2.7. “Signal Transfer Point (STP)” гэдэг нь үүрэн холбооны сүлжээний элементүүдийн хооронд SS7 дохиоллын мессэжийг дамжуулах, замчлах үүрэгтэй үүрэн холбооны сүлжээний бие даасан элемент, модулийг;

- 1.2.8. “Дугаартайгаа шилжих үйлчилгээний төв” (цаашид ДШҮТ гэх) гэдэг нь Харилцаа холбооны зохицуулах хороотой байгуулсан гэрээний үндсэн дээр дугаартайгаа шилжих үйлчилгээг хэрэгжүүлэх үндсэн үүрэг бүхий хуулийн этгээдийг;
- 1.2.9. “Хэрэглэгч” гэдэг нь үүрэн холбооны урьдчилсан болон дараа төлбөрт үйлчилгээ авч буй иргэн, хуулийн этгээдийг;
- 1.2.10. “Хүсэлт гаргагч” гэдэг нь дугаартайгаа шилжих үйлчилгээ авахаар хүсэлт гаргасан хэрэглэгчдийг;
- 1.2.11. “Урьдчилсан төлбөрт хэрэглэгч” гэдэг нь урьдчилсан төлбөрт үйлчилгээний үнэ тарифийн систем эсвэл урьдчилсан төлбөрт карт хэрэглэгчдийг;
- 1.2.12. “Хугацаа хэтэрсэн төлбөр” гэдэгт дараа төлбөрт хэрэглэгч оператортой байгуулсан гэрээний дагуу нэхэмжилсэн үйлчилгээний төлбөрийг тогтоосон хугацаанд төлөөгүй байхыг;
- 1.2.13. “Төвлөрсөн мэдээллийн сан” (цаашид “ТМС” гэх) гэдэгт дугаартайгаа шилжсэн хэрэглэгчдийн мэдээллийн нэгдсэн бүртгэлийг;
- 1.2.14. “ДШҮ-ний дотоод мэдээллийн сан” гэдэг нь оператор тус бүрт ДШҮ-ний дуудлагыг чигүүлэхэд шаардлагатай мэдээллийн нэгдсэн бүртгэлийг;

### **1.3. Дугаартайгаа шилжих үйлчилгээний ерөнхий зарчим**

Дугаартайгаа шилжих үйлчилгээнд дараах ерөнхий зарчмыг баримтална. Үүнд:

- 1.3.1. Дугаартайгаа шилжих үйл ажиллагааны талаарх мэдээллийг оролцогчдод ил тод, хүртээмжтэй байлгах;
- 1.3.2. Хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэх, үл ялгаварлах;
- 1.3.3. Үйлчилгээний шуурхай байдлыг хангах;
- 1.3.4. Дугаартайгаа шилжих үйлчилгээг хэрэгжүүлэхэд аливаа саад учруулахгүй байх;

## **2. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ**

### **2.1. Харилцаа холбооны зохицуулах хорооны эрх, үүрэг**

- 2.1.1. Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.13-т заасны дагуу дугаартайгаа шилжих үйлчилгээг нэвтрүүлэх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, уг үйлчилгээтэй холбоотой зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 2.1.2. Харилцаа холбооны зохицуулах хороо нь дугаартайгаа шилжих үйлчилгээг нэвтрүүлэхтэй холбогдуулан Дугаартайгаа шилжих үйлчилгээний төв байгуулах ажлыг зохион байгуулна.
- 2.1.3. Дугаартайгаа шилжих үйлчилгээтэй холбоотой зохицуулалтын баримт бичиг боловсруулан батална.
- 2.1.4. Дугаартайгаа шилжих үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор Харилцаа холбооны зохицуулах хороо нь холбогдох хурал, хэлэлцүүлэг эсвэл талуудын хамтарсан уулзалтыг зохион байгуулж ажиллана.
- 2.1.5. Дугаартайгаа шилжих үйлчилгээний төв болон оператор хооронд гарсан санал, гомдлыг шийдвэрлэнэ.

## **2.2. Дугаартайгаа шилжих үйлчилгээний төвийн эрх, үүрэг**

- 2.2.1. Үйл ажиллагааны дотоод журмыг боловсруулан Харилцаа холбооны зохицуулах хороогоор батлуулан мөрдөнө.
- 2.2.2. ДШҮТ нь үйл ажиллагаандаа ил тод, нээлттэй, үл ялгаварлах зарчмыг баримтална.
- 2.2.3. ДШҮТ нь ТМС-тай байх бөгөөд энэ журмын 2.3.8-д заасан операторуудын дотоод мэдээллийн сантай синхрон холболттой байна.
- 2.2.4. ДШҮТ нь хэрэглэгчийн мэдээллийг бүртгэх, шинэчлэх, дугаартайгаа шилжих үйлчилгээний техник зохицуулалт хийх, найдвартай ажиллагааг хангаж ажиллана.
- 2.2.5. Дугаартайгаа шилжих үйлчилгээг хэрэгжүүлэхтэй холбоотой шаардлагатай мэдээллийг операторуудаас шаардах эрхтэй.
- 2.2.6. Үйл ажиллагааны болон шилжсэн хэрэглэгчдийн мэдээлэл, операторуудын өгөгдлийг тухай бүр шинэчлэн баталгаажуулна.
- 2.2.7. Дугаартайгаа шилжих үйлчилгээтэй холбоотой бүхий л мэдээллийг 3-аас доошгүй жилийн хугацаанд хадгална.
- 2.2.8. ТМС-ийн техникийн хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой зохих шаардлагыг хангаж ажиллахыг операторуудаас шаардана.
- 2.2.9. Төвлөрсөн мэдээллийн санд гарсан ямар нэгэн системийн алдаа болон дугаартайгаа шилжих үйлчилгээтэй холбоотой гэмтэл саатал гарсан тохиолдолд оролцогчдод мэдэгдэж, нэн даруй шаардлагатай арга хэмжээг авна.
- 2.2.10. Сүлжээний найдвартай ажиллагааг хангаж, техникийн шинэчлэл, өргөтгөл, засвар үйлчилгээг тодорхой үе шаттайгаар гүйцэтгэж байх ба энэ талаар операторуудад урьдчилан мэдэгдэнэ.
- 2.2.11. Дугаартайгаа шилжих үйлчилгээг үзүүлж байгаатай холбоотой үйлчилгээний төлбөрийг зохих журмын дагуу операторуудаас нэхэмжлэх, шаардах эрхтэй
- 2.2.12. Хэрэглэгчийн дуудлагын төвийг байгуулах, хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцлөөр хангана.
- 2.2.13. Хэрэглэгч болон оператороос ирсэн гомдол, саналыг шийдвэрлэж, хариу мэдэгдэх үүрэгтэй.
- 2.2.14. Дугаартайгаа шилжих үйлчилгээний талаарх холбогдох мэдээллийг Харилцаа холбооны зохицуулах хороонд улирал тутам тайлагнана.

## **2.3. Операторуудын эрх, үүрэг**

- 2.3.1. Дугаартайгаа шилжих үйлчилгээг хэрэгжүүлэх техникийн нөхцлийг бүрдүүлэх, шинэчлэх, урсгал засвар үйлчилгээг тогтмол хийх, хэрэглэгчийн мэдээлэл болон мэдээллийн урсгалыг хамгаалах үүрэгтэй.
- 2.3.2. Дугаартайгаа шилжиж буй хэрэглэгчид тодорхой нэг операторыг сонгохыг тулгах, хэрэглэгчийн хүсэлтээс үндэслэлгүйгээр татгалзахыг хориглоно.
- 2.3.3. Дугаартайгаа шилжих үйлчилгээний хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх журамтай байна.
- 2.3.4. Хүсэлт гаргагчид дугаартайгаа шилжих үйлчилгээг ДШҮТөвөөс тогтоосон хугацаанд үзүүлэх үүрэгтэй.
- 2.3.5. Дугаартайгаа шилжсэн хэрэглэгчийн талаарх мэдээллийг ДШҮТ-д цаг тухайд нь мэдээлэх, зохих бүртгэлийг хийлгэнэ.
- 2.3.6. ДШҮТ-д болон бусад операторт өгч буй мэдээллийн үнэн зөвийг хариуцах үүрэгтэй.

- 2.3.7. Оператор нь дугаартайгаа шилжих үйлчилгээг хэрэгжүүлэхдээ дугаар чиглүүлэх үйл ажиллагааг АСQ аргаар STP ашиглан зохион байгуулна.
- 2.3.8. Төвлөрсөн мэдээллийн сангийн шинэчлэгдсэн мэдээллийг оператор тус бүр өөр дээрээ шинэчилж байх шаардлагатай.
- 2.3.9. Оператор нь дугаартайгаа шилжих үйлчилгээний дотоод мэдээллийн санг зохион байгуулна.
- 2.3.10. Дугаартайгаа шилжих үйлчилгээг хэрэгжүүлэхэд бусад операторын зүгээс үзүүлж буй саад бэрхшээлийг таслан зогсоохыг Харилцаа холбооны зохицуулах хорооноос шаардах эрхтэй.

#### **2.4. Донор операторын эрх, үүрэг**

- 2.4.1. Донор оператор энэхүү журмын 3.4.-т заасны дагуу хүсэлт гаргагчийн мэдээлэл, мэдүүлгийг хянаж тогтоосон хугацаанд ДШҮТ-д хариуг өгөх үүрэгтэй.
- 2.4.2. Дугаартайгаа шилжиж буй хэрэглэгч хүлээн авагч оператор руу шилжих хүртэл авч байсан бүх үйлчилгээг хэвээр үзүүлэх үүрэгтэй.

#### **2.5. Хүлээн авагч операторын эрх, үүрэг**

- 2.5.1. Хүсэлт гаргагчийн хүсэлтийг хүлээн авч хянаад энэ журмын 3.1.-ийн 3.1.1, 3.1.2, 3.1.4 дэх хэсэгт заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд уг хүсэлтээс татгалзах эрхтэй.
- 2.5.2. Дугаартайгаа шилжих үйлчилгээний хүсэлтийг хүлээн авах, ДШҮТ-д шилжүүлэх, хүсэлтийг шийдвэрлэсэн талаар хэрэглэгчдэд мэдээллэх үүрэгтэй.
- 2.5.3. Дугаартайгаа шилжсэн хэрэглэгчид үзүүлж байгаа үйлчилгээ нь чанарын хувьд тухайн операторын бусад хэрэглэгчиддээ үзүүлж байгаа үйлчилгээтэй ижил байлгах үүрэгтэй.

### **3. ДУГААРТАЙГАА ШИЛЖИХ ХҮСЭЛТ БОЛОН БҮРТГЭЛ**

#### **3.1. Хүсэлт гаргагч эрх бүхий этгээд**

- 3.1.1. Дараа төлбөрт хэрэглэгч дугаартайгаа шилжихийн тулд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
  - 3.1.1.1. Үйлчилгээ эрхлэгчтэй байгуулсан гэрээний дагуу тухайн дугаарын үндсэн ашиглагч байх;
  - 3.1.1.2. Төлбөр тооцооны үлдэгдэлгүй байх;
  - 3.1.1.3. Хугацаа хэтэрсэн төлбөр тооцоогүй байх;
- 3.1.2. Урьдчилсан төлбөрт хэрэглэгч дугаартайгаа шилжихийн тулд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
  - 3.1.2.1. Үйлчилгээ эрхлэгчтэй байгуулсан гэрээний дагуу тухайн дугаарын үндсэн ашиглагч байх;
  - 3.1.2.2. Урьдчилсан төлбөрт хэрэглэгч нь дансны үлдэгдэлгүй байх;
- 3.1.3. Хүсэлт гаргагч нь хуулийн этгээд бол энэхүү журмын 3.1.1 болон 3.1.2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангахаас гадна тухайн хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд байна.
- 3.1.4. Хүсэлт гаргагч өмнө нь дугаартайгаа шилжих үйлчилгээг ашиглаж байсан бол 90 хоногийн дараа дахин дугаартайгаа шилжих үйлчилгээг сонгон үйлчлүүлэх боломжтой болно.

3.1.5. Хүсэлт гаргагч нь 14 хоногийн дотор шилжин очсон операторын үйлчилгээний чанарт сэтгэл ханамжгүй байгаа бол донор операторт буцах боломжтой болно.

### **3.2. Хүсэлт хүлээн авах**

3.2.1. Хүлээн авагч оператор нь холбогдох журмын дагуу хүсэлт гаргагчийн хүсэлтийг хүлээн авна.

3.2.2. Хүлээн авагч оператор нь хүсэлт гаргагчийн холбогдох мэдээллийг хянаж дугаартайгаа шилжих үйлчилгээний төвд хүргүүлнэ. Үүнд:

3.2.2.1. Хүсэлт гаргагчийн мэдээлэл (Овог нэр, регистрийн дугаар)

3.2.2.2. Хүсэлт гаргагчийн утасны дугаар

3.2.2.3. Донор болон хүлээн авагч операторын нэр

3.2.2.4. Бусад

- Төлөгдөөгүй төлбөрийн үлдэгдэл

- Өмнөх операторт төлбөр төлсөн билл, лизинг болон бусад үүрэг хариуцлага

- IMEI кодын бүртгэл

### **3.3. Хүсэлт шалгах**

3.3.1. Донор операторын зүгээс хүсэлт гаргагчийн мэдээлэл, хүсэлтийг хянаж дугаартайгаа шилжих үйлчилгээний төвд хүргүүлнэ. Үүнд:

3.3.1.1. Хүсэлт гаргагчийн үндсэн мэдээлэл;

3.3.1.2. Хүсэлт гаргагчийн утасны дугаар;

3.3.1.3. Хүсэлт гаргагчийн нэр;

3.3.1.4. Хүсэлт гаргагчийн регистрийн дугаар;

3.3.1.5. Шилжих боломжтой эсэх талаарх мэдээлэл;

3.3.1.6. Төлбөр төлсөн билл;

3.3.1.7. Төлөгдөөгүй дүн;

3.3.1.8. IMEI кодын бүртгэл;

### **3.4. Хүсэлт идэвхжүүлэх**

3.4.1. Хүлээн авагч оператор нь дугаартайгаа шилжих хүсэлт гаргагчийн үйлчилгээг идэвхжүүлэхдээ урьдчилсан төлбөрт хэрэглэгч бол урьдчилсан эсвэл дараа төлбөрт рүү, дараа төлбөрт хэрэглэгч бол багц бууруулахгүйгээр зөвхөн дараа төлбөрт үйлчилгээнд холбоно.

3.4.2. ДШҮТ нь хүлээн авагч оператороос ирүүлсэн хүсэлтийг хүлээн авна.

3.4.3. ДШҮТ нь энэхүү журмын 3.2.1-ийн дагуу ирүүлсэн хүсэлтийг донор оператороор 3.3.1-ийн дагуу шалгуулж баталгаажуулна.

3.4.4. ДШҮТ нь донор оператороор 3.3.1-ийн дагуу ирүүлсэн шилжүүлэхийг зөвшөөрсөн мэдэгдлийг үндэслэн хүсэлт гаргагчийн донор оператор дахь үйлчилгээг зогсоох хүсэлтийг донор операторт мэдэгдэнэ.

3.4.5. Донор оператор нь хэрэглэгчийн үйлчилгээг зогсоосон тухай мэдээллийг ДШҮТ-д мэдэгдэнэ.

3.4.6. ДШҮТ хүсэлт гаргагчийн үйлчилгээг идэвхжүүлсэн тухай мэдээллийг хүлээн авагч операторт мэдэгдэнэ.

- 3.4.7. ДШҮТ нь дугаартайгаа шилжих үйлчилгээг идэвхжүүлэх, зогсоох хүсэлтийг хүлээж аваад ТМС-ийн мэдээллийн санг шинэчилнэ.
- 3.4.8. Донор болон хүлээн авагч оператор нь дугаартайгаа шилжих үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж, үйлчилгээний найдвартай байдлыг ханган ажиллана.

### **3.5. Дугаартайгаа шилжих үйлчилгээг цуцлах**

- 3.5.1. Дугаартайгаа шилжсэн хэрэглэгч үйлчилгээг цуцлах тухай хүсэлтийг хүлээн авагч операторт гаргасан тохиолдолд хүлээн авагч оператор холбогдох журмын дагуу шийдвэрлэнэ.
- 3.5.2. Хүлээн авагч оператор хэрэглэгчийн Дугаартайгаа шилжих үйлчилгээг цуцалсан тухай мэдээллийг ДШҮТ-д мэдээлнэ.
- 3.5.3. ДШҮТ нь үйлчилгээг цуцалсан тухай донор операторт мэдэгдэнэ.

## **4. ГОМДОЛ МАРГААН ХҮЛЭЭН АВАХ, ШИЙДВЭРЛЭХ**

### **4.1. Гомдол мэдүүлэх**

- 4.1.1. Дугаартайгаа шилжих үйлчилгээний үйл ажиллагаатай холбоотой санал, гомдлыг тухайн операторууд, ДШҮТ-ийн хэрэглэгчийн дуудлагын төвд хүсэлт гаргагч иргэн, хуулийн этгээд эсвэл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд мэдүүлэх эрхтэй.
- 4.1.2. ДШҮТ болон операторууд хоорондоо харилцан санал гомдол, мэдүүлж болно.
- 4.1.3. ДШҮТ болон операторууд хооронд үүссэн маргааныг зөвшилцлөөр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд эс бөгөөс Харилцаа холбооны зохицуулах хороонд мэдүүлэх эрхтэй.

### **4.2. Гомдлыг шийдвэрлэх**

- 4.2.1. ДШҮТ болон оператор тус бүрийн гомдол, саналыг холбогдох журмын дагуу шийдвэрлэнэ.
- 4.2.2. Хэрэглэгчийн дуудлагын төвд ирүүлсэн гомдол, саналыг ДШҮТ нь зохих журмын дагуу шийдвэрлэнэ.

### **4.3. Төлбөр тооцоо**

- 4.3.1. Дугаартайгаа шилжих үйлчилгээтэй холбоотойгоор оператор хооронд төлбөр тооцооны гэрээ байгуулж болно.
- 4.3.2. Дугаартайгаа шилжих үйлчилгээтэй холбоотой хэрэглэгчийн төлбөр тооцоог операторууд өөрсдийн харилцан тохиролцсон хугацаанд тогтмол хийж болно.
- 4.3.3. Донор оператор нь дугаартайгаа шилжиж буй хэрэглэгчээс өөрийн үйлчилгээний төлбөрийг хэрэглэсэн хугацаагаар тасалбар болгож (Hot Bill) шууд хандан нэхэмжлэх эрхтэй.
- 4.3.4. Донор оператор нь дараа төлбөрт хэрэглэгчийн барьцаа мөнгийг төлбөрийн нэхэмжлэх гүйцэд гарах хүртэл хадгалж, төлбөрийг суутган авч зөрүүг хүлээн авагч операторт хэрэглэгчийн нэрээр шилжүүлж болно.
- 4.3.5. Хэрэглэгчийн барьцаа мөнгө донор операторын нэхэмжилсэн төлбөрийг барагдуулахад хүрэлцэхгүй тохиолдолд донор оператор зөрүү дүнг хэрэглэгчээс нэхэмжилнэ.

- 4.3.6. Лизингийн нөхцлөөс хамааран хүлээн авагч оператор нь үлдэгдэл тооцоог шалгах шаардлагатай бөгөөд хэрэглэгчтэй хийсэн үйлчилгээний гэрээний дагуу лизингийн зээлийг цуцлах эсэхийг шалгана. Зээлийн төлбөр тооцоо дууссан бол заавал баримтыг хавсаргана.
- 4.3.7. Дугаартайгаа шилжих үйлчилгээний төлбөрийг Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны баталсан “Харилцаа Холбооны үйлчилгээний тариф тогтоох зөвлөмж, аргачлал”-ыг үндэслэн тогтооно.

#### **4.4. Дугаартайгаа шилжих үйлчилгээнд саад болох нөхцөл**

- 4.4.1. Хэрэглэгч гар утасны лизинг болон үүрэн холбооноос бусад үйлчилгээний хугацаа хэтрээгүй төлбөрийн үлдэгдэлтэй байгаа нь дугаартайгаа шилжих үйлчилгээнд хамрагдахад саад болохгүй.
- 4.4.2. Энэхүү журам хүчин төгөлдөр болохоос өмнө хэрэглэгчид хөнгөлттэй нөхцлөөр (лизинг гэх мэт) худалдсан гар утасны төлбөрийг хэрэглэгч барагдуулсан тохиолдолд дугаартайгаа шилжих үйлчилгээнд хамрагдаж болно.
- 4.4.3. Энэхүү журам хүчин төгөлдөр болсноос хойш хэрэглэгчид энэ журмын 4.4.2 дахь хэсэгт заасан хөнгөлөлттэй нөхцөл олгосны төлөө түүнийг дугаартайгаа шилжих үйлчилгээнд хамрагдахгүй байх үүрэг хүлээлгэхийг хориглоно.

#### **4.5. Хэрэглэгчийн нууцыг хадгалах үүрэг**

- 4.5.1 Хүлээн авагч болон донор оператор, ДШҮТ нь хэрэглэгчийн хувийн мэдээлэл болон харилцаа холбооны сүлжээгээр дамжиж буй бүх төрлийн мэдээ, мэдээллийн нууцыг чандлан хадгалах үүрэгтэй.

### **5. БУСАД**

#### **5.1. Хариуцлага**

- 5.1.1. Энэхүү журмын 4.4 -р зүйлийн 4.4.3 дах хэсэгт заасныг зөрчсөн этгээдэд Өрсөлдөөний тухай хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 5.1.2. Энэхүү журмын 4.5-р зүйлийн 4.5.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн тохиолдолд гэм буруутай этгээдэд Харилцаа холбооны тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 5.1.3. Харилцаа холбооны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.9 дэх хэсгийг зөрчсөн тохиолдолд мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хороо тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.
- 5.1.4. ДШҮТ болон операторууд нь энэхүү журамд заасан үүргээ зөрчсний улмаас бусдад хохирол учруулсан тохиолдолд Иргэний хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.